



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Сувиллын яслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,
Булган аймаг	тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
2023 он	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn
	Аудитын менежер: Ж.Энхцоодол
	Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
	Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3-4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.14 № 05

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН СУВИЛЛЫН ЯСЛИЙН
ЭРХЛЭГЧ Г.МЯГМАРСҮРЭН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын яслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын яслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.12 -д хязгаарлалтад хамрагдаагүй.

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын яслийн 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний хүрээнд нийт 189,154.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 189,086.6 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 99 хувьтай байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020068

Сувиллын яслийн шууд захирагч нь 2022 онд Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 94 хувийн биелэлтэйгээр тайлагнасан

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,538,730.20</u>	<u>10,966,052.70</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	14,538,730.20	10,966,052.70
351	Түүхий эд материал	422,000.00	206,000.00
35130	Эм боох материал	422,000.00	206,000.00
354	Хангамжийн материал	14,116,730.20	10,760,052.70
35410	Бичиг хэргийн материал	30,000.00	30,000.00
35420	Аж ахуйн материал	11,653,148.20	10,276,148.20
35440	Түлш, шатах тослох материал	100,000.00	100,000.00
35450	Барилгын засварын материал	95,000.00	95,000.00
35460	Хүнсний материал	2,069,132.00	258,904.50
35470	Бусад хангамжийн материал	169,450.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,515,591.48</u>	<u>33,970,243.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	32,515,591.48	33,970,243.89
392	Биет хөрөнгө	10,605,591.48	12,060,243.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	37,849,300.00	37,849,300.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,574,394.68	-34,777,013.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,882,520.00	7,569,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,673,921.83	-1,917,214.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,620,100.00	4,057,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,498,012.01	-722,198.50
393	Биет бус хөрөнгө	21,910,000.00	21,910,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,910,000.00	21,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>47,054,321.68</u>	<u>44,936,296.59</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>47,054,321.68</u>	<u>44,936,296.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	47,054,321.68	44,936,296.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,374,126.73	59,374,126.73
51101	Өмч: - төрийн	37,464,126.73	37,464,126.73
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	21,910,000.00	21,910,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-12,319,805.05	-14,437,830.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-12,319,805.05	-12,319,805.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,118,025.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>47,054,321.68</u>	<u>44,936,296.59</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	165,442,000.00	193,900,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	4,746,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	4,746,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	4,746,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,746,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,442,000.00	189,154,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	165,442,000.00	189,154,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	165,442,000.00	189,154,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	171,226,539.22	196,018,925.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,161,088.46	174,166,917.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,161,088.46	174,166,917.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,296,085.82	105,191,095.83
210101	Үндсэн цалин	63,381,268.95	71,417,350.83
210102	Нэмэгдэл	31,616,816.87	25,007,849.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,298,000.00	3,156,000.00
210104	Урамшуулал	00.00	2,190,996.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,418,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,643,075.42	13,149,574.00
210201	Тэтгэврийн даатгал	8,992,995.15	8,941,710.16
210202	Тэтгэмжийн даатгал	931,869.39	1,051,965.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	745,495.52	841,592.75
210204	Ажилгүйдлийн даатгал	171,764.65	211,390.38
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,950.71	2,102,914.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,342,371.00	27,512,892.41
210301	Гэрэл, цахилгаан	662,192.00	1,757,864.41
210302	Түлш, халаалт	15,958,800.00	24,081,816.00
210303	Цэвэр, бохир ус	1,721,379.00	1,673,212.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,793,107.00	2,578,750.00
210401	Бичиг хэрэг	593,400.00	327,600.00
210402	Тээвэр, шатахуун	30,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	141,570.00	124,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,000.00	415,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,873,137.00	359,100.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,353,000.00
2105	Нормативт зардал	5,850,448.00	19,355,757.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,640.00	415,020.00
210502	Хоол, хүнс	5,553,858.00	17,331,287.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	113,950.00	1,609,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	505,000.00	1,290,000.00

210604	Урсгал засвар	505,000.00	1,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,500.00	1,797,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,000.00	1,450,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	347,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,970,501.22	3,291,347.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,970,501.22	3,291,347.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,065,450.76	21,852,007.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,447,400.00	21,783,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,917,400.00	21,273,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	530,000.00	510,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,618,050.76	68,307.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,618,050.76	68,307.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-5,784,539.22</u>	<u>-2,118,025.09</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-5,784,539.22</u>	<u>-2,118,025.09</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>165,442,000.00</u>	<u>189,154,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>165,442,000.00</u>	<u>189,154,900.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	165,442,000.00	189,154,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	165,442,000.00	189,154,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>164,412,030.00</u>	<u>189,154,900.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>164,412,030.00</u>	<u>189,154,900.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>139,346,579.24</u>	<u>167,302,892.24</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,255,172.82	105,191,095.83
210101	Үндсэн цалин	63,340,355.95	71,417,350.83
210102	Нэмэгдэл	31,616,816.87	25,007,849.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,298,000.00	3,156,000.00
210104	Урамшуулал	00.00	2,190,996.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,418,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,643,075.42	13,149,574.00
210201	Тэтгэврийн даатгал	9,074,017.66	8,941,710.16
210202	Тэтгэмжийн даатгал	850,846.88	1,051,965.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	745,495.52	841,592.75
210204	Ажилгүйдлийн даатгал	171,764.65	211,390.38
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,950.71	2,102,914.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,342,371.00	27,512,892.41

210301	Гэрэл, цахилгаан	662,192.00	1,757,864.41
210302	Түлш, халаалт	15,958,800.00	24,081,816.00
210303	Цэвэр, бохир ус	1,721,379.00	1,673,212.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,065,170.00	1,201,750.00
210401	Бичиг хэрэг	338,800.00	327,600.00
210402	Тээвэр, шатахуун	130,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	141,570.00	124,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,000.00	415,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,800.00	335,100.00
2105	Нормативт зардал	8,210,790.00	17,160,080.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	398,640.00	199,020.00
210502	Хоол, хүнс	6,991,050.00	15,521,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	821,100.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	1,290,000.00
210604	Урсгал засвар	600,000.00	1,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,230,000.00	1,797,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	880,000.00	1,450,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	347,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,065,450.76	21,852,007.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,447,400.00	21,783,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,917,400.00	21,273,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	530,000.00	510,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,618,050.76	68,307.76
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,618,050.76	68,307.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,029,970.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,029,970.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,029,970.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,029,970.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,029,970.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,029,970.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,374,126.73	00.00	-6,535,265.83	00.00	52,838,860.90
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,374,126.73	00.00	-6,535,265.83	00.00	52,838,860.90
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,784,539.22	00.00	-5,784,539.22
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,374,126.73	00.00	-12,319,805.05	00.00	47,054,321.68
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,374,126.73	00.00	-12,319,805.05	00.00	47,054,321.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,374,126.73	00.00	-12,319,805.05	00.00	47,054,321.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,118,025.09	00.00	-2,118,025.09
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,374,126.73	00.00	-14,437,830.14	00.00	44,936,296.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,154,900.00	189,154,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,154,900.00	189,154,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,371,200.00	167,302,892.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,248,300.00	105,191,095.83
210101	Үндсэн цалин	73,266,700.00	71,417,350.83
210102	Нэмэгдэл	26,657,100.00	25,007,849.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,324,500.00	3,156,000.00
210104	Урамшуулал	00.00	2,190,996.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,418,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,149,600.00	13,149,574.00
210201	Тэтгэврийн даатгал	8,941,700.00	8,941,710.16
210202	Тэтгэмжийн даатгал	1,052,000.00	1,051,965.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	841,600.00	841,592.75
210204	Ажилгүйдлийн даатгал	210,400.00	211,390.38
210205	Эрүүл мэндийн даатгал	2,103,900.00	2,102,914.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,522,700.00	27,512,892.41
210301	Гэрэл, цахилгаан	1,763,700.00	1,757,864.41
210302	Түлш, халаалт	23,619,000.00	24,081,816.00

210303	Цэвэр, бохир ус	2,140,000.00	1,673,212.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,201,800.00	1,201,750.00
210401	Бичиг хэрэг	327,600.00	327,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	124,100.00	124,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	415,000.00	415,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	335,100.00	335,100.00
2105	Нормативт зардал	17,161,300.00	17,160,080.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	199,020.00
210502	Хоол, хүнс	15,521,300.00	15,521,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,290,000.00	1,290,000.00
210604	Урсгал засвар	1,290,000.00	1,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,797,500.00	1,797,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,450,500.00	1,450,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	347,000.00	347,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21783700.00	21783700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,783,700.00	21,783,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,273,700.00	21,273,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	510,000.00	510,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,154,900.00	189,154,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	189,154,900.00	189,154,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	189,154,900.00	189,154,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08.00	08.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын ясли нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон өрх толгойлсон эцэг, эхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сувилан чийрэгжүүлж энгийн цэцэрлэгт шилжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Тус ясли нь 2022 онд нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу халамжийн үйлчилгээнд хамруулж тэднийг хамт олны дунд нийгэмшүүлэх зорилгын хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж, хүүхдийг дээдэлж эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах зорилтыг тавьж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүүхдийн байгууллагад мөрдөгдөх эрүүл ахуйн дүрэм, стандарт орчныг мөрдөх зөвлөмж, хүүхэд хамгааллын баримт бичиг, хүүхэд хамгаалах ёс зүйн дүрэм, ХХҮГ-ын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/85 дугаар тушаалаар "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтын журам"-ыг батлуулан журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит /аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

Тухайн байгууллага нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд дотоод хяналтыг "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтын журамд заасны дагуу төлөвлөн явуулдаг байна.

НББ-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд байгууллагын удирдлага болон дотоод аудитын ажилтан хяналт тавьж 2021 онд шилэн дансны үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтад хяналт тавин ажилласан байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сайжрах, хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой учир дотоод аудит шаардлагатай гэж үзэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын яслийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын ясли нь Булган аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын ясли нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	0	
Бараа материал	14,538.70	10,966.00	(3,572.70)
Үндсэн хөрөнгө	32,515.60	33,970.30	1,454.70
Нийт хөрөнгө	47,054.30	44,936.30	(2,118.00)
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	47,054.30	44,936.30	(2,118.00)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	47,054.30	44,936.30	(2,118.00)

Дээрх хүснэгтээс харахад Бараа материалын дансны үлдэгдэл 3,572.7 мянган төгрөгөөр буурсан байгаа нь хүнсний материалын дансны үлдэгдэл өмнөх оноос буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,454.7 мянган төгрөгөөр өссөн байгаа нь ашиглалтын хугацаа нь дууссан, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталж устгасан, мөн элэгдлийн хугацаа нь дууссан хөрөнгүүдийг дахин үнэлсэнтэй холбоотой хуримтлагдсан элэгдлийн дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 195,800.0 мянган төгрөг, нийт зарлагыг 195,800.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлаас 3,600.0, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын зардлаас 455.05, үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,600.0 мянган төгрөгөөр бууруулж 189,100.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төсөлд цалингийн зардлыг нэмэгдүүлэн тооцсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 189,154.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээс гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 189,154.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 189,154.9 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/ Зөрүү Биелэлт	
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	163 228,6	163 160,4	68,2	99,96%
2	Нийтлэг үйлчилгээ	4 142,6	4 142,5	0,1	100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	21 783,7	21 783,7	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын яслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сувиллын ясли 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 1.5 хувиар буюу 2,837.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасны дагуу байгууллагын цэвэр усны хэрэглээг өмнөх оноос 48.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүүхдийн сувилал нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 12 удаагийн нийт 180,024.5 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, 6.4.8-д заасан 6 удаагийн 21,783.8 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,582.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 894.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 687.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасныг зөрчин 50 нас хүрсэн албан хаагчид 80.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын нормативыг баримтлаагүй нийт 814.5 мянган төгрөгийн хоолны зардлыг илүү зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас ажил олгогчийн НДШ 687.6 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажил олгогчийн НДШ 687.6 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй байна.	1	687.1					1	687.1				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасныг зөрчин 50 нас хүрсэн албан хаагчид 80.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.	1	80.0	1	80.0								
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын нормативыг баримтлаагүй нийт 814.5 мянган төгрөгийн хоолны зардлыг илүү зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй.	1	814.5	1	814.5								
Дүн	3	1581.6	2	894.5			1	687.1				

